

## НИЙСЛЭЛИЙН ЦАГДААГИЙН ГАЗАР

**[ЭРҮҮЛЖҮҮЛЭХ, СААТУУЛАХ ТӨВИЙН ДЭРГЭД ЦАХИЛГААН  
ДЭД ӨРТӨӨ /КТПН/ БАЙГУУЛАХ, ХАЛААЛТЫН УУРЫН ЗУУХАНД  
ЦАХИЛГААН ЗУУХ СУУРИЛУУЛАХ ТУХАЙ]  
ХУДАЛДАН АВАХ**

ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер  
шалгаруулалт/  
гэрээний нэр:

Цахилгаан дэд өртөө /КТПН/ байгуулах, халаалтын  
уурын зууханд цахилгаан зуух суурилуулах тухай

Тендер  
шалгаруулалт/  
гэрээний дугаар:

НЦГ/201908003

Улаанбаатар хот  
2019 он

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2019.08.23

**[Нийслэлийн цагдаагийн газар]** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **[Цахилгаан дэд өртөө /КТПН/ байгуулах, халаалтын уурын зууханд цахилгаан зуух суурилуулах]**-ыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **[2019 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 11:00 цаг]**-аас өмнө Цахим худалдан авах ажиллагааны систем ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn))-д аж ахуй нэгжийн үндэсний тоон гарын үсгийн гэрчилгээг ашиглан нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **[2019 оны 09 дүгээр сарын 02-ны]**-ны өдрийн **[11:40 цаг]**<sup>1</sup>-т нээнэ.

Дотоодны давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Бага тойруу,  
Ж.Самбуугийн гудамж-18, өөрийн байр, Утас: 70191210,  
Нийслэлийн цагдаагийн газар**

---

<sup>1</sup> Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:

  - (а) Үнийн санал;
  - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
  - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
  - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
  - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**

4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.

4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.

4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын**

5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30хоногийн хугацаанд хүчинтэй байна.

**хүчинтэй  
байх хугацаа**

- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
  - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
  - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТОӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> <li>1. Сүүлийн [2] жилийн санхүүгийн тайлан /шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт/;</li> <li>2. Байгууллагын Улсын бүртгэлийн гэрчилгээг ирүүлэх шаардлагагүй бөгөөд <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим системээс хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийг шалгана.</li> <li>3. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэл ирүүлнэ.</li> <li>4. Цахим татварын тодорхойлолт ирүүлэх шаардлагагүй бөгөөд <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> мэдээллийн системээс тендерт оролцогчийн татварын дутуу үлдэгдэлийн талаарх мэдээллийг шалгана. /Тендерт оролцогч нь тендер нээсэн өдрийн байдлаар татварын дутуу үлдэгдэлгүй байх ёстой./</li> <li>5. Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт ирүүлнэ.</li> <li>6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолт ирүүлнэ.</li> <li>7. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогч мэдүүлгээ албан бичгээр ирүүлнэ.</li> <li>8. Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмуудын жагсаалт ирүүлнэ.</li> <li>9. Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 оны аль нэг онд борлуулалтын орлого нь захиалагчийн батлагдсан нийт төсөвт өртгийн 200 хувиас багагүй байна.</li> <li>10. Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 онуудын аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгийн 150 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ажлыг дор хаяж нэг удаагийн гэрээгээр гүйцэтгэсэн байх ба гэрээ болон гэрээ дүгнэсэн актын хуулбар, захиалагчийн тодрхойлолтыг ирүүлнэ.</li> <li>11. Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: <b>[Цахилгаан эрчим хүчний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл]</b></li> <li>12. ТШӨХ-д заасан материалуудын аль нэгийг ирүүлээгүй тохиолдолд уг тендерээс татгалзах үндэслэл болно.</li> </ol>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>[Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Бага тойруу, Ж.Самбуугийн гудамж-18, өөрийн байр, Утас: 70191210, Нийслэлийн цагдаагийн газар]</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>[Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-д аж ахуйн нэгжийн үндэсний тоон гарын үсгийн гэрчилгээг ашиглан нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.]</b></p> <p>Огноо: <b>[2019 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр]</b></p> <p>Цаг: <b>[11 цаг 00 минут]</b></p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>[Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо, Бага тойруу, Ж.Самбуугийн гудамж-18, өөрийн байр, Утас: 70191210, Нийслэлийн цагдаагийн газар.]</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>[Уг тендер нь цахим тендер</b></p>

	<p>шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>)-д аж ахуйн нэгжийн үндэсний тоон гарын үсгийн гэрчилгээг ашиглан нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр ирүүлнэ.]</p> <p>Огноо: <b>[2019 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр]</b></p> <p>Цаг: <b>[11 цаг 40 минут]</b></p>
<b>ТӨӨЗ 2.3</b>	Долдугаар бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ.
<b>ТӨӨЗ 6.2</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>[Багц-1 Цахилгаан дэд өртөө /КТПН/ байгуулах, Багц-2 Цахилгаан халаалт /зуух/ суурилуулах]</b>

**Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ  
/АЖЛЫН ДААЛГАВАР/**

<b>д/д</b>		<b>Суурилуулах тоног төхөөрөмжийн үзүүлэлт</b>
1	Цахилгаан зуух /тогоо/	<ol style="list-style-type: none"> <li>1. Тухайн объектийг буюу 1400м/кв талбайг бүрэн халаах хүчин чадалтай 95квт-аас дээш хүчин чадалтай цахилгаан тогоо 1 ширхэг, 50квт-аас дээш хүчин чадалтай нөөц цахилгаан тогоо 1 ширхэг, нийт 2 цахилгаан тогоо байх,</li> <li>2. 600квт-аас дээш хүчин чадалтай, цуваа хэлбэртэй халаалтын ялтаст солилцуур суурилуулах,</li> <li>3. Халаагч нь зэсээр хийгдсэн металтай байх шаардлагатай бөгөөд халаагчийн нөөц 8 ширхэгээс дээш байх шаардлагатай,</li> <li>4. АВВГ 3*951*70 ба түүнээс дээш хүчин чадалтай цахилгааны кабель холбох,</li> <li>5. Олон улсын стандарт, шаардлага хангасан бусад холбох сантехник, цахилгааны материал байх,</li> <li>6. “УБЦТС” ТӨХК-иас гаргасан техникийн нөхцөл ажлын даалгаврын дагуу чанартай, бүрэн хийж гүйцэтгэх.</li> </ol>
2	Цахилгаан дэд өртөө /КТПН/ шинээр байгуулах	<ol style="list-style-type: none"> <li>1. 250 кВа буюу түүнээс дээш хүчин чадалтай трансформатор, станц суурилуулах,</li> <li>2. “УБЦТС” ТӨХК-ий 2019 оны 08-р сарын 01-ний өдрийн 15/02816/19 тоот техникийн нөхцөл, ажлын даалгаврын дагуу чанартай, бүрэн хийж гүйцэтгэх.</li> </ol>

**Жич:** Тендерт оролцогчийн санал болгосон тоног төхөөрөмж, бусад хэрэгслүүдийн хамгийн сайн чанартай, техникийн үзүүлэлт, хүчин чадал өндөр байдал, гүйцэтгэх хугацаа зэргийг үнэлгээнд харгалзан үзнэ.

## Техникийн нөхцөл:

УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨРИЙН  
ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Д.БАЯРСАЙХАН

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар 15/02816/19

2019 оны 02 сарын 01 өдөр

Улаанбаатар хот

### Нэг. Ерөнхий мэдээлэл:

1.1	Хүсэлтийн дугаар:	19-51-001194
1.2	Хэрэглэгчийн нэр, регистр:	ЭРҮҮЛЖҮҮЛЭХ СААТУУЛАХ ТӨВ Төрийн байгууллага, РД: 9126716
1.3	Хэрэглэгчийн байршил:	Улаанбаатар Чингэлтэй 12-р хороо, Булгын 22В
1.4	Ажил үйлчилгээний зориулалт:	Үйлчилгээ
1.5	Техникийн нөхцөл олгох үндэслэл:	1) Газар эзэмших эрхийн 2013 оны 000434972 тоот гэрчилгээ. 2) Нийслэлийн цагдаагийн газрын 2019 оны 25/4270 тоот албан бичиг
1.6	Техникийн нөхцөлийн ангилал:	Шинэ холболт
1.7	Тооцооны бүрэн чадал:	108 кВА /Нэг зуун найм/ (тоогоор) (үсгээр)

### Хоёр. Холболтын цэг:

2.1	110/35/10 кВ-ын Телевиз дэд станцын 10 кВ-ын Шонхор фидерийн АТП-190 дэд өртөөний оролт анкер тулгуураас салбарлалт авч салбар шугамын эхний тулгуурт хуурай салгуур суурилуулан агаарын болон кабель шугам татаж шинээр баригдах дэд өртөөг тэжээх.
-----	--

### Гурав. Тоолуур, хэмжих хэрэгсэл:

3.1	Дэд өртөөний 0,4 кВ талын ерөнхий оруулганд СХЗҮТ-ийн загварын туршилтанд орсон DLMS протоколыг дэмждэг 3 фазын баталгаат, бүрэн электрон тоолуур, ачаалалд тохирсон гүйдлийн трансформаторыг тусгай хайрцагт суурилуулах.
-----	--

### Дөрөв. Тусгай заалтууд:

4.1	Олон улсын стандартын шаардлага хангасан, алдагдал багатай 160 кВА чадалтай, 10/0.4 кВ-ын хүчдэлийн, хүчдэл тохируулгын 5 шатлалтай трансформатор бүхий дэд өртөөг /КТПН/ өөрийн эзэмшлийн газарт шинээр барих.
4.2	Богино залгааны гэмтэл заагч датчийг суурилуулах. Техникийн тодорхойлолтыг Техникийн бодлого зохицуулалтын хэлтсээс авах.
4.3	10 кВ-ын Шонхор фидерийн тулгуур № 51, АТП-190 дэд өртөөний оролт анкер тулгуурыг төмөр бетон тулгуураар шинэчлэн солих. УБЦТС ТӨХК-ийн эзэмшлийн дэд станц, шугам тоноглолд хийгдэх өргөтгөл, шинэчлэлийн ажлыг харьяа түгээх төвөөр гүйцэтгүүлэх.
4.4	Буусан тоног төхөөрөмжийг Монгол улсын засгийн газрын 2001 оны 263-р



	тогтоолын 2.6.3-т заасны дагуу УБЦТС ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд шилжүүлэн өгөх.
4.5	Цахилгаан хангамжийн III зэрэглэлийн шугамаас холбогдож байгаа тул цахилгаан эрчим хүч тасарсан үед тэжээх нөөц эх үүсгүүр / дизель генератор/ суурилуулах.

**Тав. Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:**

5.1	Шугам, дэд өртөөний "Ажлын зураг төсөл"-ийг тухайн нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө хариуцсан нэгж болон бусад шаардлагатай байгууллагуудтай зөвшилцөн, мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах.
5.2	Энэхүү техникийн нөхцөлийн дагуу тавигдах шугам, тоноглолууд нь өмнө нь ашиглагдаж байгаагүй шинэ байх ба Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн баталсан "Техникийн шаардлагын тодорхойлолт"-ыг хангасан байх шаардлагатай. Техникийн шаардлагын тодорхойлолтыг <a href="http://www.tog.mn">www.tog.mn</a> хаягаар орж хууль, дүрэм цонхноос үзэх.
5.3	Засгийн газрын 2001 оны 263 тоот тогтоолоор батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн заалтуудыг мөрдлөг болгох.
5.4	"Эрчим хүчний тухай хууль"-ийн 30.1.8-д заасны дагуу өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, засвар үйлчилгээ, баталгаажуулалтыг бүрэн хариуцах ба харьяа түгээх төв болон бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй ашиглалт үйлчилгээний гэрээ байгуулах.
5.5	"Эрчим хүчний тухай" хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу шугам сүлжээний хамгаалалтын зурвас дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
5.6	Дэд өртөө, щитний газардуулга болон шугам тоноглолын хэмжилт, туршилтыг норм, дүрмийн дагуу хийлгэн холбогдох газраар шалгуулж протокол авсан байх.
5.7	Угсралтын ажлын явцад тус компанийн харьяа түгээх төвөөр хяналт тавиулж, холбогдох баримтыг бүрдүүлсэн байх.
5.8	Цахилгаан угсралтын ажлыг тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагаар Аюулгүй ажиллагааны дүрэм, Техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн дүрмийн дагуу гүйцэтгүүлэх.
5.9	Цахилгаан эрчим хүчний тооцоог Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ хувьцаат компанийн харьяа хэрэглэгчдэд үйлчлэх төвтэй хийх.


**Зургаа. Бусад:**

6.1	Энэхүү техникийн нөхцөлийн дагуу холболтыг 1 жилийн хугацаанд хийж гүйцэтгэх бөгөөд энэ хугацаанд цахилгаан сүлжээнд холбогдоогүй тохиолдолд шинээр техникийн нөхцөл авна.
-----	--

Комиссын гишүүд:

 Л.Ганзориг

 Б.Азаяа

 Т.Мөнхболд

 А.Зоригт

Боловсруулсан:

 Г.Наранбаяр

## Тав. ЗУРАГ

6.1. Ажлын зургийг тендерт шалгарсан компани захиалагчийн төсөвт өртөгт багтаан гүйцэтгэж, хүлээн авах улсын комисст хүлээлгэн өгөхөд бэлтгэнэ.

6.2. Ажлын талбайн зураг:

Дэд станц КТПН шинээр байгуулах ажлын талбай



Цахилгаан зуух суурилуулах уурын зуухны барилга



**Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ**  
 /Тендерт оролцогч нь дараах хүснэгтийн  
 ажлын нэр төрөл, хугацаа, төсвийн тооцооллыг нөхөж бичнэ/

д/д	Гүйцэтгэх ажлын нэр, төрөл	Сар	9 сар									ДҮН
		хоног	...	...	...	...	...	...	...	...	...	
<b>Дэд станц КТПН шинээр байгуулах ажлын үе шат</b>												
1		Төл										
		Гүйц										
2		Төл										
		Гүйц										
3		Төл										
		Гүйц										
4		Төл										
		Гүйц										
5		Төл										
		Гүйц										
6		Төл										
		Гүйц										
7		Төл										
		Гүйц										
8		Төл										
		Гүйц										
9	..... Г.М	Төл										
		Гүйц										
<b>БҮГД ДҮН</b>		<b>Төл</b>										<b>19,800,000</b>
		<b>Гүйц</b>										<b>19,800,000</b>
д/д	Гүйцэтгэх ажлын нэр, төрөл	Сар	9 сар									ДҮН
		хоног	...	...	...	...	...	...	...	...	...	
<b>Цахилгаан зуух /тогоо/ суурилуулах ажлын үе шат</b>												
1	Галлагаатай зуухнаас огтолгоо авах, хаалт тавих	Төл										
		Гүйц										
2	Одоо байгаа системд цахилгаан тогоог 1, 2-р хэлхээ болгох	Төл										
		Гүйц										
3	Цахилгаан тогоо суурилуулах, холбох	Төл										
		Гүйц										
4	Цахилгааны болон сантехникийн шугамын холболт хийх	Төл										
		Гүйц										
5	Кабель далдлах, шуудуу ухах, булах	Төл										
		Гүйц										
6	ТР-ээс цахилгаан тогоонд тэжээлийн холболт хийх	Төл										
		Гүйц										
7	Бусад шаардлагатай ажлыг жагсаах ..... Г.М	Төл										
		Гүйц										
<b>БҮГД ДҮН</b>		<b>Төл</b>										<b>29,600,000</b>
		<b>Гүйц</b>										<b>29,600,000</b>

## Долоо.ЖИШИГ МАЯГТ

### ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

#### **ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДЭД БӨГӨӨД НИЙСЛЭЛИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА Д.ЯДАМДОРЖ ТАНАА**

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b>                         | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.  |
| <b>2. Төслийн менежерийн шийдвэр</b>                        | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.   |
| <b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b> | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.  |
| <b>4. Аюулгүй байдал</b>                                    | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.<br>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| <b>5. Зааварчилгаа</b>                                      | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй  |
| <b>6. Маргааныг шийдвэрлэх</b>                              | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |

### **Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ**

- |                                     |   |
|-------------------------------------|---|
| <b>7. Ажлын хөтөлбөр</b>            | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.<br>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| <b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b> | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.  |
| <b>9. Зөрчил, гологдол арилгах</b>  | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа <sup>2</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.<br>9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд   |

<sup>2</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх** 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

## **В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

- 11. Үе шатны ажлын хуваарь** 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх** 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги** 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>3</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

## **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

- 14. Ажил дуусгах** 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах** 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо** 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт,** 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил,

<sup>3</sup> Алдангийг хэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүннээр гэрээний үнийн 5-10%-иас хэтрэхгүй.

<b>засвар, үйлчилгээний гарын авлага</b>	инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
<b>18. Гэрээг цуцлах</b>	<p>17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.</p> <p>18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.</p> <p>18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:</p> <ul style="list-style-type: none"> <li>(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;</li> <li>(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;</li> <li>(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;</li> <li>(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;</li> <li>(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.</li> </ul> <p>18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.</p>
<b>19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр</b>	<p>19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.</p> <p>19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.</p>
<b>20. Гүйцэтгэлээс чөлөөлөх</b>	<p>20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа</p>

ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

#### Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ<sup>4</sup>

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <b>[Цахилгаан дэд өртөө /КТПН/ байгуулах, халаалтын уурын зууханд цахилгаан зуух суурилуулах тухай, НЦГ/201908003],</b>
ГЕН 2.1	Ажил нь <b>[Цахилгаан дэд өртөө /КТПН/ байгуулах, халаалтын уурын зууханд цахилгаан зуух суурилуулах тухай, НЦГ/201908003]-</b> аас бүрдэнэ.  Ажлын талбай нь <b>[Чингэлтэй дүүрэг, 12-р хороо, Эрүүлжүүлэх, саатуулах төв]-</b> д байрших ба ажлын талбайн зураг №1, 2-д зааснаар тодорхойлогдсон болно.
ГЕН 3.1	Төслийн менежер нь <b>[Нийслэлийн цагдаагийн газар]</b>
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр <b>[2019.09.13]</b>  Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр <b>[2019.09.30]</b> <sup>5</sup>
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш <b>[5]</b> хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа <b>[360]</b> хоног байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн <b>[0,5%]</b> байна. <sup>6</sup>  Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <b>[10%]</b> байна.
ГЕН 17.1	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг <b>[2019.09.27]-</b> ны дотор гаргаж өгнө.  Гүйцэтгэлийн зургийг <b>[2019.09.27]-</b> ны дотор гаргаж өгнө.  Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ <b>[10%]</b> байна.
ГЕН 19.1	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын <b>[20%]-</b> иар тооцно.

<sup>4</sup> Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

<sup>5</sup> Ажлыг хэсэгчлэн дуусгахаар төлөвлөсөн бол эдгээр хугацааг жагсаана.

<sup>6</sup> Ажлыг хэсэг хэсгээр дуусгах болон хэсэг бүрт алданги хэрэглэх бол энд тусгана.



## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### ЗАХИАЛАГЧ

### ГҮЙЦЭТГЭГЧ

\_\_\_\_\_ (Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_ (Тамга, тэмдэг)

\_\_\_\_\_ (Гарын үсэг)

\_\_\_\_\_ (Гарын үсэг)

\_\_\_\_\_ (Албан тушаал)

\_\_\_\_\_ (Албан тушаал)

### **[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай/\_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;

- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

#### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

#### **ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**САНХҮҮЖИЛТИЙН ХУВААРЬ**

д/д	Хөтөлбөрийн нэр, гэрээний дугаар	Санхүүжилтийн задаргаа		Нийт дүн /НӨАТ орсон/
		Урьдчилгаа 0 хувь	Гүйцэтгэлээр 100 хувь	
1	<b>Цахилгаан дэд өртөө /КТПН/ байгуулах тухай, НЦГ/201908003/</b>	0	29,600,000	29,600,000
2	<b>Халаалтын уурын зууханд цахилгаан зуух суурилуулах тухай, НЦГ/201908003/</b>	0	19,800,000	19,800,000
<b>ДҮН</b>				<b>49,400,000₮</b>